

ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ШАЛГАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРООНЫ ГИШҮҮНД НЭР ДЭВШҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

Нэг.Зорилго

1.1.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсэг, Монголын Хуульчдын холбоо /цаашид “Хуульчдын холбоо” гэх/-ны дүрмийн 8.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хороо /цаашид “Шалгалтын хороо” гэх/-ны гишүүнд нэр дэвшүүлэх ажлыг зохион байгуулахад оршино.

Хоёр. Хороонд төлөөллөө оруулах эрх бүхий этгээд, төлөөлөгчийн тоо

2.1. Хуульчийн эрх зүйн байдлын тухайн хуулийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсэгт “Хуульчдын холбооны Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хороо нь Хуульчдын холбооны гишүүн, хуульч профессоруудын төлөөлөл оролцсон 13 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.”

2.2. Монголын Хуульчдын холбооны дүрмийн 8.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шалгалтын хороо нь шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн хорооноос тус бүр хоёр, хуульч профессоруудаас долоон төлөөлөл оролцсон нийт арван гурван гишүүний бүрэлдэхүүнтэй байна.” гэж тус тус заасан.

Гурав.Нэр дэвшүүлэх үйл ажиллагаа

3.1.Шалгалтын хорооны гишүүнд нэр дэвшүүлэх ажиллагааг 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 12 цагийн хооронд явуулна.

3.2. Шалгалтын хорооны гишүүнд нэр дэвших сонирхолтой хуульч өөрөө нэрээ дэвшүүлнэ.

3.3. Хуульчдын холбооны Шүүгч, Прокурор, Өмгөөлөгчдийн хорооны Удирдах зөвлөл, магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн их, дээд сургуулиудын захиргаа нь нэрээ дэвшүүлсэн хуульчдаас 3-аас доошгүй хуульчдыг тус тус сонгон холбогдох мэдээллийг Хуульчдын холбооны Тамгын газарт хүргүүлнэ.

3.4. Хуульчдын холбооны Зөвлөл нь Шүүгч, Прокурор, Өмгөөлөгчдийн хорооны Удирдах зөвлөл, магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн их, дээд сургуулиудын профессоруудаас сонгон ирүүлсэн хуульчдаас энэхүү удирдамжийн 2.1-д заасан төлөөллийг Шалгалтын хорооны гишүүнээр сонгоно.

Дөрөв.Нэр дэвшигч хуульчид тавигдах шаардлага

4.1.Шалгалтын хорооны гишүүнд нэр дэвших хуульч нь дараах шаардлагыг хангана:

- Сүүлийн 3 жилд хуульчийн мэргэжлийн хариуцлага, ёс зүйн зөрчил гаргаагүй байх;
- Хуульчийн нийтлэг үүргийн зөрчилгүй байх;
- Тухайн нэр дэвшүүлж буй хорооны гишүүн байх;
- Мэргэжлээрээ 8-аас доошгүй жил ажилласан байх;
- Эрх зүйн тодорхой салбараар таваас доошгүй жил мэргэшин ажилласан байх;
- Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;

Тав.Бүрдүүлэх материал

5.1.Нэр дэвшигч нь дор дурдсан материалыг бүрдүүлж, Монголын Хуульчдын холбооны Тамгын газарт хүргүүлнэ. Үүнд:

- төрийн албан хаагчийн анкет, 2 хувь цээж зураг (4x6);
- иргэний үнэмлэхний хуулбар;
- мэргэжлээрээ ажилласныг нотлох баримт (Ажлын газрын тодорхойлолт, эсвэл нийгмийн даатгалын дэвтэр);
- магистр эсхүл түүнээс дээш боловсролын зэргийн дипломын хуулбар;

Зургаа.Материал ирүүлэх хугацаа, хаяг

6.1.Хорооны гишүүнд нэр дэвшигчийн материалыг 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 12 цаг хүртэл Хуульчдын холбооны Тамгын газар хүлээн авна.